

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алиман тойром ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/21/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Даланзадгад хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 250

танай _____-ны № _____-т

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН АЛИМАН
ТОЙРОМ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Х.МАНДУХАЙ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алиман тойром ОНӨААТҮГ-ын 2022 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Алиман тойром ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Алиман тойром ОНӨААТҮГ нь тайлант онд 3.5 сая төгрөгийн зардлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн ч нотлох баримтыг аудитад ирүүлээгүй, бараа материалыг 1.6 сая төгрөгөөр бууруулсан ч бараа материалын тайлан гаргаж аудитад ирүүлээгүй, тайлант онд 1.3 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсоныг нотлох боломжгүй, тайлант онд өглөгийг 0.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэснийг нотлох боломжгүй хөрөнгө, бараа материалын тооллогын баримт ирүүлээгүй, өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.2.3-д заасантай тус тус нийцээгүй, "иж бүрэн байх", "тохиолдсон байх", "тасалбар болголт", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 3.5 сая төгрөгийг зардлыг бүртгэсэн ч орлогоо бүртгээгүй байна.

016020355

Аудитын гол асуудал

Мөнгөн гүйлгээний тайланд бараа материал худалдан авахад хөрөнгө зарцуулсан гэж тайлагнасан боловч нотлох баримтыг аудитад ирүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	3.7	2.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3.9	2.6
Нийт хөрөнгийн дүн	7.6	4.6
Нийт өр төлбөрийн дүн	13.1	13.6
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	(5.5)	(9.0)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7.6	4.6
Орлогын дэлгэрэнгүй тайлан		
Борлуулалтын орлогын дүн		
Үйл ажиллагааны зардал болон ББӨ-н дүн	(3.5)	(3.5)
Татварын өмнөх ашиг	(3.5)	(3.5)
Татварын дүн	-	-
Татварын дараах ашиг	(3.5)	(3.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмч	(2.0)	(5.5)
Хуримтлагдсан ашиг	(3.5)	(3.5)
Эцсийн үлдэгдэл	(5.5)	(9.0)
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	-	-
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	-
Үйл ажиллагааны ЦМГ	-	-
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.3	0.3
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.3	0.3
Зорилтот түвшин	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт борлуулалтын орлого	-	-
Үйл ажиллагааны зардал	-	-
Үйл ажиллагааны бус зардал	-	-
Нийт зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг	-	-
Татвар	-	-
Татварын дараах ашиг	-	-

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй байна.

Аудитаар нийт 15.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 15.3 сая төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2022 онд 13.7 сая төгрөгийн өглөгтэй, 0,07 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Аудитад авлага өглөгийн тооцоо нийлсэн актыг бүрэн ирүүлээгүй, бараа материалаар өглөгийг төлж барагдуулсан гэх боловч санхүүгийн тайланд өглөгийг бууруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллаж өр төлбөрийг бүрэн барагдуулан ажиллах

2. Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 1.6 сая төгрөгийн бараа материалыг өр төлбөртөө өгсөн гэх боловч зардлаар бүртгэн өр төлбөрийг бууруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг өр төлбөрийн оронд өгсөн бол санхүүгийн тайланд холбогдох засварыг хийн өр төлбөрийг бууруулан ажиллах

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 166 мэдээлэл мэдээлэхээс 129 мэдээллийг хуулийн хүрээнд хугацаанд нь бүрэн байршуулсан, 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хугацаа болоогүй байгаа тул мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв тогтмол мэдээлж хэвших

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	13,661.0					1	13,661.0				
Бараа материал данстай холбоотой	1	1,645.3					1	1,645.3				
	2	15,306.3					2	15,306.3				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1						1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
6	ТӨОНААТҮГ	1	1					1	
	НИЙТ	1	1					1	